

Орхоны хөндийн БЦГ-ын Хамгаалалтын захиргааны

2015 оны 07 сарын мэдээ

Байгалийн нөөц, хамгаалал

2015 оны 7-р сарын 10-11-нд Хархорин сумын ойн санд Цагтуулт, Ар мод 300 га, Их нарийн, Мухдаг, Уртын аманд 350 га нийт 650 га талбайд Мон Таксац ХХК, Хархорин сумын байгаль хамгаалагч, хамгаалалтын захиргааны мэргэжилтэн, байгаль хамгаалагчид хамтран ойн хортон устгалын ажлыг хийж гүйцэтгэлээ.



Хархорин сумын Орхон голын хөндийд 2 отоглох цэг, Бат-Өлзий сумын Хустын рашаанд 2, Хятруунд 1, Могойтод аялагчдын нэвтрэх цэг 1-ийг байгуулан тухайн нутгийн иргэд, бүлэг нөхөрлөлүүдэд байгаль хамгаалах менежментийн зарим чиг үүргийг хариуцуулахаар болоод байна.

Тус цэгүүдийн тохижилт, төслийн ажил байдалтай танилцахаар НҮБХХ, ТХГН-ын сүлжээг бэхжүүлэх нь төслийн ажлын хэсэгтэй хамтран явцын хяналт хийлээ. Мөн төслөөс орон нутгийн бүлэг нөхөрлөлүүдийг дэмжиж санхүүжүүлсэн бичил төслүүдийн явцтай танилцлаа.



Хархорин сумын Жалбаа багийн Их эрэн нөхөрлөлийн хэрэгжүүлсэн төслийн гүйцэтгэл 100%-тай, чанарын шаардлага хангасан байна. Төслөөр Мөстийн амны булаг хашиж, нөхөрлөлийн гишүүдийн амжиргааг дэмжих тариалангийн талбайг хашиж төмс тарьж ургуулжээ.



Аялал жуулчлал

Бат-Өлзий сумын Хүрхрээ, Төвхөн, Хуст, Үүртийн тохойн үзэсгэлэнт газруудыг түшиглэн аялал жуулчлал эрхэлдэг нутгийн иргэдтэй байгаль хамгаалж газар ашиглах түр гэрээг орон нутгийн захиргаатай хамтран байгуулж хяналт тавьж ажиллаж байна.

Хархорин сумын Орхоны хөндийн БЦГ-т аялагч жуулчдад зориулсан отоглох цэгийг барьж тохижууллаа. Хамгаалалтын захиргаа сум орон нутгийн удирдлагууд, Онцгой байдлын газартай хамтран отоглох цэг барих газрыг сонгосон юм.



Энэ жил Хархорин суманд 2 отоглох цэг хийгдэхээс эхнийх нь ийнхүү ашиглалтанд орлоо.



Отоглох цэг байгуулснаар Орхон голын хөвөөний хог, 00-ын асуудал шийдэгдэх ба тэнд хариуцан ажиллах гэрээт байгаль хамгаалагч аялал жуулчлалын улиралд амрагч нарт мэдээлэл өгч, орчин бохирдуулахгүй байх, зөв зохистой, ая тухтай амрахад анхаарч ажиллах юм.



Мэдээлэл, сургалт, сурталчилгаа

Хамгаалалтын захиргааны жолооч С.Мөнхбаяр үндэсний их баяр наадмаар Хархорин сумандаа түрүүлэн ЗААН цолоор шагнууллаа.



Дотоодын аялагчдын зорин очдог гол бүс нутгууд болох Хятруун, Хуст, Могойтын аялал жуулчлалын бүс нутгуудад мэдээлэл сурталчилгааны 24 нүүр бүхий 12 самбаруудыг байрлууллаа.



Хархорин суманд Өндөр гэгээний Даншигийн их наадам 2015 оны 07 сарын 25-27-ний өдрүүдэд Хотол түмнээрээ дэнж хотойтол сайхан наадлаа.

Баяр наадмын үеэр хамгаалалтын захиргаа 2 байгаль хамгаалагчийг Хархоринд хүч нэмэгдүүлэн ажиллууллаа. Эдгээр өдрүүдэд байгаль хамгаалагчид тусгай хамгаалалттай газар нэвтэрсэн 1200 гаруй гадаад дотоодын аялагчдад тасалбар тасалж хууль сурталчилсан ажиллаа.



Мөн төслийн санхүүжилтээр хийгдэх “Орхоны хөндийн” БЦГ-ын баримтат киноны зураг авалтын багтай хамтран Хятруун, Хүрхрээ, Могойт, Үүртийн тохой үзэсгэлэнт газруудаар явж тухай бүсийн иргэд, бүлэг нөхөрлөлүүд, Өвөрхангай аймаг, Бат-Өлзий, Уянга, Хархорин сумын Засаг дарга нараас ярилцлага авлаа.

Мэдээ нэгтгэсэн: Мэргэжилтэн Ч.Суурьтогтох